



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 05 сарын 13 өдөр

Дугаар 198

Улаанбаатар хот

**Үл хөдлөх хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020-2021 онд Сангийн сайдын багцаас (Татварын ерөнхий газрын захиалгаар) санхүүжүүлэн барьж ашиглалтад оруулсан нийт 5,998,391,700.00 (таван тэрбум есөн зуун ерэн найман сая гурван зуун ерэн нэгэн мянга долоон зуун) төгрөгийн үнэ бүхий барилга, байгууламжийг хавсралтад заасны дагуу Увс, Хөвсгөл, Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Татварын ерөнхий газрын дарга Б.Заяабал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан бүртгэх асуудлыг шийдвэрлүүлэх;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-г үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн
№... дугаар тогтоолын хавсралт



Увс, Хөвсгөл, Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн үндсэн
хөрөнгөд бүртгэх үл хөдлөх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр, байршил	Барилгын хүчин чадал	Гүйцэтгэлээрх дүн /төгрөгөөр/	Улсын комиссын актын дугаар
1	Татварын хэлтсийн барилга (цогцолбор) /Баянхонгор аймаг, Баянхонгор сум/	2 давхар, зоорьтой, нийт 1489.7м2	2,043,583,200.00	2020-10-28 2020/46
2	Татварын хэлтсийн барилга (цогцолбор) /Хөвсгөл аймаг, Мөрөн сум/	2 давхар, зоорьтой, нийт 1489.72м2	1,910,884,900.00	2021-11-20 ББКД-67-47/21
3	Татварын хэлтсийн барилга (цогцолбор) /Увс аймаг, Улаангом сум/	4 давхар, зоорьтой, нийт 1080м2	2,043,923,600.00	2021-10-22 34/2021
	Нийт дүн		5,998,391,700.00 (таван тэрбум есөн зуун ерэн найман сая гурван зуун ерэн нэгэн мянга долоон зуун)	